МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛИЙН БООМТ, ТЭДГЭЭРИЙН ДЭГЛЭМИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгиин газар /цаашид "Талууд" гэж нэрлэнэ/, хоёр улсын хоорондын сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцаа, ард түмнүүдийн уламжлалт найрамдлыг цаашид бэхжүүлэн хөгжүүлэх, хоёр улсын эдийн засаг, худалдааны харилцаанд тус дөхөм үзүүлэх зорилгоор, 1991 оны "Монгол, Хятадын хилийн боомт болон тэдгээрийн дэглэмийн тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийн оронд Монгол, Хятадын хилийн боомт болон тэдгээрийн дэглэмийн тухай шинэ хэлэлцээр байгуулах шаардлагатай гэж үзэн, 1988 оны "Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Гэрээ" болон 1989 оны "Иргэд харилцан зорчих журмын тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хоорондын Хэлэлцээр"-ийг иш үндэс болгон, эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн зорилгод доорх нэр томъёог дараах утгаар ойлгоно:

1. "Хилийн боомт" болон "боомт" нь адил утгатай байх бөгөөд Монгол, Хятадын хилийн хоёр талд орших, иргэд, тээврийн хэрэгсэл, бараа эд юмсад хяналт шалгалт хийж бүртгэн хилээр нэвтрүүлэх зориулалтаар тусгайлан тогтоосон газрыг хэлнэ.

Хилийн боомт нь хоёр талын болон олон улсын шинжтэй байна.

Хоёр талын шинжтэй боомт гэж зөвхөн Монгол, Хятадын иргэд, тээврийн хэрэгсэл, бараа эд юмсыг хил нэвтрүүлэх боомтыг хэлнэ.

Олон улсын шинжтэй боомт гэж Монгол, Хятадын болон гуравдахь улс (бүс нутаг)-ын иргэд, тээврийн хэрэгсэл, бараа бусад эд юмсыг хил нэвтрүүлэх боомтыг хэлнэ.

Дээр дурдсан хоёр төрлийн хилийн боомтыг байнгын ажиллагаатай, түр ажиллагаатай гэж ангилна.

2. "Хил орчмын нутаг"-т хил залгаж буй Монгол Улсын сум болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хот, шянь (уезд), хошуу багтана.

3. "Хил орчмын иргэн" гэж хил орчмын нутагт байнга оршин суудаг хоёр талын иргэнийг хэлнэ.

4. "Давагдашгүй хүчин зүйл" гэж урьдчилан харах, урьдчилан сэргийлэх, гэтлэн давах боломжгүй нөхцөлийг хэлнэ.

2 дугаар зүйл

1. Талууд Монгол, Хятадын хилийн хэсэг дээр дор дурдсан хилийн боомт ажиллуулахаар тохиролцов. Үүнд:

Монгол Улсын талаас	БНХАУ-ын талаас
1. Даян	Хуншаньзюй
2. Булган	Такашикэн
3. Байтаг	Улиастай
4. Бургастай	Лаоемяо
5. Шивээхүрэн	Сэхээ
6. Гашуун сухайт	Ганц мод
7. Ханги	Мандал
8. Замын-Үүд(төмөр зам)	Эрээн хот (төмөр зам)
9. Замын-Үүд(авто зам)	Эрээн хот (авто зам)
10. Бичигт	Зүүн хатавч
11 Сүмбэр	Рашаан
12. Баянхошуу	Өвдөг
13. Хавирга	Ар Хашаат

2. Энэхүү зүйлийн нэгд дурдсан хилийн боомтын байршил, төрөл, ангилал, нээх хугацаа, ажиллах хуваарийг Нэгдүгээр хавсралтаар тодорхойлов.

3 дугаар зүйл

1. Энэхүү зүйлийн хоёрт заасан "Монгол, Хятадын хил орчмын нутагт зорчих үнэмлэх" бүхий иргэд үнэмлэхэд заасан хилийн боомтоор хил нэвтэрч зөвшөөрсөн хил орчмын нутагт болон хугацааны дотор үйл ажиллагаа явуулна. Онцгой тохиолдолд Талуудын хилийн шалган нэвтрүүлэх байгууллагууд зөвшөөрснөөр энэхүү Хэлэлцээрийн хоёрдугаар зүйлд заасан тухайн үед ажиллаж байгаа бусад боомтоор хил нэвтэрч болно.

Хоёр талын иргэд тус тусын дотоодын хууль тогтоомж, Талуудын байгуулсан эсвэл оролцсон холбогдох олон улсын гэрээнд зааснаар хууль ёсны хүчин төгөлдөр хил нэвтрэх эрхийн баримт бичгээр энэхүү Хэлэлцээрийн Нэгдүгээр хавсралтад заасан хилийн боомтоор хил нэвтэрнэ.

Аль нэг гуравдагч улс (бүс нутаг)-ын иргэн энэхүү Хэлэлцээрийн Нэгдүгээр хавсралтад дурдсан олон улсын шинжтэй боомтоор хил нэвтрэхдээ хүчин төгөлдөр паспорт, орох визтэй байх бөгөөд тухайн улс хоёр талтай тусгай хэлэлцээр байгуулсан бол тэр хэлэлцээрийн заалтын дагуу хил нэвтэрнэ. Хэрэв энэхүү Хэлэлцээрийн Нэгдүгээр хавсралтад дурдсан хоёр талын шинжтэй боомтоор хил нэвтрэх шаардлага гарвал хүчин төгөлдөр паспорт, орох визтэй байх бөгөөд хоёр талын гадаад харилцааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авна.

2. "Монгол, Хятадын хил орчмын нутагт зорчих үнэмлэх"-ийг Талуудын эрх бүхий байгууллагаас дор дурдсан хүмүүст олгоно.

а/Талуудын хилийн худалдаа эрхэлдэг хил орчмын иргэд (тэдгээрийн хөлслөн ажиллуулж буй жолооч, ажилчин гэх мэт),

б/нөгөө талын хил орчмын нутагт байгаа төрөл садантайгаа уулзахаар яваа хил орчмын иргэд,

в/хил орчмын нутгийн бусад арга хэмжээнд урилгаар оролцох хил орчмын иргэд,

г/Талуудын хилийн албаны ажилтан (Талуудын хилийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнээс бусад),

д/Талуудын хилийн боомтын хяналт шалгалтын ажилтан.

"Монгол, Хятадын хил орчмын нутагт зорчих үнэмлэх" нь 1 жилийн хугацаанд хүчинтэй олон удаагийн, 3 сарын хугацаанд хүчинтэй нэг удаагийн гэсэн хоёр төрөл байна. Монголын талын зорчих үнэмлэхийг монгол, хятад, англи хэлээр, Хятадын талын зорчих үнэмлэхийг хятад, монгол, англи хэлээр тус тус үйлдэнэ (Энэхүү үнэмлэхийн загвар болон тайлбарыг Хоёрдугаар хавсралт, Гуравдугаар хавсралтаар тодорхойлов).

3. "Монгол, Хятадын хил орчмын нутагт зорчих үнэмлэх"-ээр хил нэвтрэх хоёр талын иргэн 16 нас хүрээгүй хүүхдээ дагуулан явах тохиолдолд түүний овог нэр, хүйс, төрсөн он, сар, өдрийг үнэмлэхэд тэмдэглэх бөгөөд сүүлийн үеийн цээж зургийг нь наасан байна.

Дагуулан явах хүүхдийн тоо хоёроос хэтрэхгүй байна.

4. "Монгол, Хятадын Хил орчмын нутагт зорчих үнэмлэх"-ээр хил нэвтэрсэн хоёр Талын иргэний нөгөө Талын нутагт байх удаа бүрийн хугацаа 30 хоногоос хэтрэхгүй байна. Нэг талын үнэмлэх эзэмшигч нөгөө талдаа 30 хоногоос илүү хугацаагаар байх зайлшгүй шаардлага гарвал нөгөө Талын эрх бүхий байгууллагад хугацаагаа сунгуулах хүсэлт тавих бөгөөд тухайн байгууллага түүнийг зөвхөн нэг удаа 30 хоногоос хэтрэхгүйгээр сунгана.

5. Нэг Талын иргэн "Монгол, Хятадын хил орчмын нутагт зорчих үнэмлэх"-ээ нөгөө Талын нутагт үрэгдүүлбэл тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэж, энэхүү байгууллагаас олгосон үнэмлэхээ үрэгдүүлснийг нотолсон бичигтэйгээр хил нэвтэрнэ (Үнэмлэхээ үрэгдүүлснийг нотолсон бичгийн загварыг Дөрөвдүгээр хавсралтаар тодорхойлов).

6. Талууд Монгол, Хятадын хил орчмын нутгийн засаг захиргааны нэгжийн жагсаалтыг Тавдугаар хавсралтаар тодорхойлов. Нэг Талын хил орчмын нутгийн засаг захиргааны нэгжид өөрчлөлт гарвал нөгөө Талд тухай бүрт нь дипломат шугамаар мэдэгдэнэ.

7. Нэг Талын хилийн худалдаа эрхлэгч хүмүүс, тээврийн хэрэгсэл, бараа эд юмс нөгөө Талын нутагт орсны дараа Талуудын эрх бүхий байгууллагаас

заасан замаар аялж, заасан талбайд ачаа тээшээ буулгана. Дээр дурдсан тээврийн хэрэгсэл нь Талуудын тохиролцсон таних тэмдэгтэй байна (Энэхүү таних тэмдгийн загварыг Зургаадугаар хавсралтаар тодорхойлов).

8. Хил нэвтрэх зорчигч болон тээврийн хэрэгслийг зохицуулах журмыг Талуудын холбогдох байгууллагууд энэ Хэлэлцээрийн үндсэн дээр тохиролцоно.

4 дүгээр зүйл

1. Хилийн боомтыг нээн ажиллуулах үеэр Талуудын хилийн хяналт шалгалтын байгууллагууд түс тусын улсын хууль тогтоомжийн дагуу үүргээ гүйцэтгэнэ. Шаардлагатай бол Талуудын хилийн хяналт шалгалтын байгууллага хяналт шалгалтын дэг журмыг хялбаршуулах асуудлаар тусгай хэлэлцээр байгуулж болно.

2. Талуудын хилийн боомтын холбогдох хяналт шалгалтын байгууллагууд хоорондоо хэлэлцээ, уулзалт хийх болон ажил хэргийн харилцаа тогтоож болно.

3. Талуудын хууль ёсны баяр, амралтын өдрүүдэд хилийн боомтыг хаана. Талуудын хууль ёсны баяр, амралтын өдрүүд:

Монголын тал: Нэгдүгээр сарын 1, Цагаан сар /шинийн нэгэн, хоёрон/, Гуравдугаар сарын 8, Зургадугаар сарын 1, Долдугаар сарын 11-12, Арван нэгдүгээр сарын 26,

Хятадын тал: Нэгдүгээр сарын 1, Цагаан сар /шинийн нэгнээс гурван/ , Тавдугаар сарын 1-3, Аравдугаар сарын 1-3.

Төмөр замын боомт нь Талуудын хоорондын холбогдох хэлэлцээрт заасан төмөр замын цагийн хуваарийн дагуу ажиллах бөгөөд дээр дурдсан баяр, амралтын өдрүүд болон боомтын ажиллах хугацааны хязгаарлалтанд хамрагдахгүй.

4. Талуудын хилийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүн, тэдгээрийн тээврийн хэрэгсэл Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Гэрээгээр олгосон эрх, үүргээ хэрэгжүүлэх үүднээс хилийн боомтыг хаасан эсвэл боомт ажиллаагүй байх үед (Энэхүү Хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн хоёрт зааснаас бусад нөхцөлд) хилийн уулзалтын замаар хил нэвтэрч болно.

5 дугаар зүйл

1. Талууд хилийн боомт шинээр нээх, ажиллаж байгаа боомтыг хаах эсвэл хилийн боомтын байршил, төрөл, ангилал, нээх хугацаа, ажиллах хуваарийг өөрчлөх асуудлыг дипломат шугамаар тохиролцоно. Энэ тухай баримт бичгийг энэхүү Хэлэлцээрийн нэмэлт болгоно.

2. Талуудын хилийн боомтын холбогдох байгууллагуудын шийдвэрлэж чадаагүй асуудлыг дипломат шугамаар зохицуулна.

6 дугаар зүйл

1. Талууд шинээр нээх эсвэл төрөл, ангиллыг нь өөрчлөх хилийн боомтыг шаардлагатай дэд бүтэц болон хилийн хяналт шалгалтын байгууллагуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлсний дараа дипломат шугамаар харилцан тохиролцсоноор нээн ажиллуулна.

2. Талуудын холбогдох байгууллагууд хилийн боомтын зураг төсөл болон барих төслийн талаар хэлэлцэхдээ хоёр талын хүмүүс, тээврийн хэрэгсэл, ачаа барааны урсгалын хөгжлийн хэтийн төлөвийг харгалзан үзнэ.

7 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн Нэгдүгээр хавсралтад дурдсан түр ажиллагаатай боомтууд ажиллахаас бусад хугацаанд онцгой тохиолдолд тухайн боомтуудыг түр нээх, хаах буюу нээхийг хойшлуулах шаардлага гарвал Талууд дипломат шугамаар таваас доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж, харилцан тохиролцоно.

2. Нийгмийн эрх ашиг, үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс буюу байгалийн ноцтой гамшиг тохиолдсон, онц халдварт өвчин, амьтан, ургамлын тахал гарч халдвар тархах аюултай байгаа болон бусад давагдашгүй хүчин зүйлийн улмаас аль нэг Тал нь хилийн боомтыг түр хаах, ажиллах хугацааг хойшлуулах буюу хил нэвтрэхийг хязгаарлаж болно. Энэ тухай таваас доошгүй хоногийн өмнө, онцгой нөхцелд арга хэмжээ авахаас 24 цагийн өмнө нөгөө Талдаа мэдэгдэнэ.

3. Энэ зүйлийн хоёрт дурдсанаас бусад тохиолдолд аль нэг Тал нөгөө Талын зөвшөөрөлгүйгээр хилийн боомтыг хаасан буюу нээхийг хойшлуулснаас нөгөө Талд учирсан хохирлыг зохих хэмжээгээр барагдуулна.

8 дугаар зүйл

Хилийн боомтоор нэвтэрч буй хүмүүс нөгөө Талын нутагт байхдаа тухайн улсын хууль тогтоомжийг мөрдөнө.

9 дүгээр зүйл

Талуудын холбогдох байгууллагууд хилийн боомтын асуудлаар харилцахдаа "Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Гэрээ"-ний холбогдох заалтыг баримтална.

10 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь Талуудын байгуулсан олон улсын бусад гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг хөндөхгүй.

11 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах буюу хэрэгжүүлэх явцад үүссэн аливаа маргаантай асуудлыг Талууд дипломат шугамаар тохиролцож шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр байх хугацаанд Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр түүнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

13 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор 1991 оны 6-р сарын 24-нд байгуулсан " Монгол, Хятадын хилийн боомт болон тэдгээрийн дэглэмийн тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр" хүчингүй болно.

14 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардагдах Талуудын дотооддоо мөрдөж буй журмыг биелүүлсэн тухайгаа бичгээр Талууд харилцан мэдэгдэн, сүүлчийн мэдэгдлийг илгээсэн өдрөөс 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээр арван жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд аль нэг Тал Хэлэлцээрийн хүчинтэй хугацаа дуусахаас 6 сарын өмнө түүнийг цуцлах тухайгаа негөө Талдаа бичгээр мэдэгдээгүй бол хүчинтэй байх хугацаа нь тав таван жилээр аяндаа сунгагдаж байна.

Энэхүү Хэлэлцээрийг 2004 оны 7 дугаар сарын 5..-ны өдөр Бээжин хотноо хятад, монгол хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй болно.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС

李肇星

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС

Нэгдүгээр хавсралт

МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛИЙН БООМТУУДЫН БАЙРШИЛ, ТӨРӨЛ, АНГИЛАЛ, НЭЭХ ХУГАЦАА, АЖИЛЛАХ ХУВААРЬ

1. Даян-Хуншаньзюй боомт

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 17 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Баян-Өлгий аймгийн Сагсай сум, БНХАУ-ын Шиньжян Уйгарын Өөртөө Засах Орны Алтай районы Фухай шянь боомтын хоёр талд оршино. Боомтын хил нэвтрэх зам нь Монгол, Хятадын Даян-Хуншаньзюйн хилийн уулзалтын зам болно.

Энэхүү боомт нь хоёр талын шинжтэй, түр ажиллагаатай.

Жил бүрийн 6 дугаар сарын 21-нээс 7 дугаар сарын 5, 8 дугаар сарын 1-20, 9 дүгээр сарын 1-15-ныг дуустал хугацаанд боомтыг нээнэ. Нээх хугацаанд монголын талаас Улаанбаатарын цагаар 12:00-19:00, хятадын талаас Бээжингийн цагаар 11:00-18:00 цагт ажиллуулна.

2. Булган-Такашикэн боомт

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 124 дүгээр тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Ховд аймгийн Булган сум, БНХАУ-ын ШУӨЗО-ы Алтай районы Чинхэ шянь боомтын хоёр талд оршино. Боомтын хил нэвтрэх зам нь Монгол, Хятадын Булган-Такашикэний хилийн уулзалтын зам болно.

Энэхүү боомт нь олон улсын шинжтэй, байнгын ажиллагаатай.

Нээх хугацаанд монголын талаас Улаанбаатарын цагаар 10:00 -19:00(зуны цагийн тооллоор 11:00-20:00), хятадын талаас Бээжингийн цагаар 10:00-19:00 цагт ажиллуулна.

3. Байтаг-Улиастай боомт

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 163 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Ховд аймгийн Булган сум, БНХАУ-ын ШУӨЗО-ы Цонжийн хотон үндэстний өөртөө засах тойргийн Читай шянь боомтын хоёр талд оршино. Боомтын хил нэвтрэх зам нь Монгол, Хятадын Байтаг Улиастайн хилийн уулзалтын зам болно.

Энэхүү боомт нь хоёр талын шинжтэй, түр ажиллагаатай.

Жил бүрийн 3, 5, 9 дүгээр сарын 16-30-ыг дуустал хугацаанд боомтыг нээнэ. Нээх хугацаанд монголын талаас Улаанбаатарын цагаар 10:00-19:00(зуны цагийн тооллоор 11:00-20:00), хятадын талаас Бээжингийн цагаар 10:00-19:00 цагт ажиллуулна.

4. Бургастай-Лаоемяо боомт

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 354 дүгээр тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Говь-Алтай аймгийн Алтай сум, БНХАУ-ын ШУӨЗО-ы Хами районы Баликунь шянь боомтын хоёр талд оршино. Боомтын хил нэвтрэх зам нь Монгол, Хятадын Бургастай-Лаоемяогийн хилийн уулзалтын зам болно.

Энэхүү боомт нь хоёр талын шинжтэй, түр ажиллагаатай.

Жил бүрийн 2, 4, 6, 8, 10, 12 дугаар сарын 11-30-ыг дуустал хугацаанд боомтыг нээнэ. Нээх хугацаанд монголын талаас Улаанбаатарын цагаар 10:00-18:00(зуны цагийн тооллоор 11:00-19:00), хятадын талаас Бээжингийн цагаар 10:00-18:00 цагт ажиллуулна.

5. Шивээхүрэн-Сэхээ боомт

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 572 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Өмнөговь аймгийн Гурван тэс сум, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Алшаа аймгийн Эзний хошуу боомтын хоёр талд оршино. Боомтын хил нэвтрэх зам нь Монгол, Хятадын Шивээхүрэн-Сэхээгийн хилийн уулзалтын зам болно.

Энэхүү боомт нь хоёр талын шинжтэй, байнгын ажиллагаатай.

Нээх хугацаанд монголын талаас Улаанбаатарын цагаар 8:00-17:00(зуны цагийн тооллоор 9:00-18:00), хятадын талаас Бээжингийн цагаар 8:00-17:00 цагт ажиллуулна.

6. Гашуун сухайт-Ганц мод боомт

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 703 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Өмнөговь аймгийн Ханбогд сум, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Баяннуур аймгийн Улаат дунд хошуу боомтын хоёр талд оршино. Боомтын хил нэвтрэх зам нь Монгол, Хятадын Гашуун сухайт- Ганц модны хилийн уулзалтын зам болно.

Энэхүү боомт нь хоёр Талын шинжтэй, байнгын ажиллагаатай.

Нээх хугацаанд монголын талаас Улаанбаатарын цагаар 8:00-17:00(зуны цагийн тооллоор 9:00-18:00), хятадын талаас Бээжингийн цагаар 8:00 -17:00 цагт ажиллуулна.

7. Ханги-Мандал боомт

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 757 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Дорноговь аймгийн Хатанбулаг сум, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Бугат хотын Дархан муумянганы холбоот хошуу боомтын хоёр талд оршино. Боомтын хил нэвтрэх зам нь Монгол, Хятадын Ханги-Замын шурангийн хилийн уулзалтын зам болно.

Энэхүү боомт нь хоёр Талын шинжтэй, түр ажиллагаатай.

Жил бүрийн 3, 5, 8, 11 дүгээр сарын 16-30-ыг дуустал хугацаанд боомтыг нээнэ. Нээх хугацаанд монголын талаас Улаанбаатарын цагаар 8:00-17:00(зуны цагийн тооллоор 9:00-18:00), хятадын талаас Бээжингийн цагаар 8:00-17:00 цагт ажиллуулна.

8. Замын-Үүд-Эрээн хот боомт (төмөр зам)

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 815 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Дорноговь аймгийн Замын-Үүд сум, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Эрээн хот боомтын хоёр талд оршино.

Энэхүү боомт нь олон улсын шинжтэй, байнгын ажиллагаатай.

9. Замын-Үүд-Эрээн хот боомт (авто зам)

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 815 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Дорноговь аймгийн Замын-үүд сум, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Эрээн хот боомтын хоёр талд оршино.

Энэхүү боомт нь олон улсын шинжтэй, байнгын ажиллагаатай. Бямба, Ням гаригуудад хэвийн ажиллана.

Нээх хугацаанд монголын талаас Улаанбаатарын цагаар 8:00-18:00(зуны цагийн тооллоор 9:00-19:00), хятадын талаас Бээжингийн цагаар 8:00-18:00 цагт ажиллуулна.

10. Бичигт-Зүүн хатавч боомт

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 1046 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошуу боомтын хоёр талд оршино. Боомтын хил нэвтрэх зам нь Монгол, Хятадын Бичигт-Зүүн хатавчийн хилийн улзалтын зам болно.

Энэхүү боомт нь олон улсын шинжтэй, байнгын ажиллагаатай.

Нээх хугацаанд монголын талаас Улаанбаатарын цагаар 8:00-17:00(зуны цагийн тооллоор 9:00-18:00), хятадын талаас Бээжингийн цагаар 8:00-17:00 цагт ажиллуулна.

11. Сумбэр-Рашаан боомт

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 1382 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Дорнод аймгийн Халхгол сум, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган аймгийн Рашаан хот боомтын хоёр талд оршино. Боомтын хил нэвтрэх зам нь Монгол, Хятадын хилийн 1382 дугаар тэмдгийн орчимд байна.

Энэхүү боомт нь олон улсын шинжтэй, түр ажиллагаатай.

Жил бүрийн 6 дугаар сарын 11-30, 7 дугаар сарын 16-30,*8 дугаар сарын 16-наас 9 дүгээр сарын 25-ныг дуустал хугацаанд боомтыг нээнэ. Нээх хугацаанд монголын талаас Улаанбаатарын цагаар 8:00-17:00(зуны цагийн тооллоор 9:00-18:00), хятадын талаас Бээжингийн цагаар 8:00 -17:00 цагт ажиллуулна.

12. Баянхошуу-Өвдөг боомт

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 1423 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Дорнод аймгийн Халхгол сум, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөлөнбуйр хотын Шинэ Барга зүүн хошуу боомтын хоёр талд оршино. Боомтын хил нэвтрэх зам нь Монгол, Хятадын Баянхошуу-Өвдөгийн хилийн уулзалтын зам болно.

Энэхүү боомт нь хоёр талын шинжтэй, түр ажиллагаатай.

Жил бүрийн 2, 5, 8, 11 дүгээр сарын 1-15-ыг дуустал хугацаанд боомтыг нээнэ. Нээх хугацаанд монголын талаас Улаанбаатарын цагаар 8:00-17:00(зуны цагийн тооллоор 9:00-18:00), хятадын талаас Бээжингийн цагаар 8:00-17:00 цагт ажиллуулна.

13. Хавирга-Ар хашаат боомт

Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн 1495 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Дорнод аймгийн Чойбалсан сум, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөлөнбуйр хотын Шинэ Барга баруун хошуу боомтын хоёр талд оршино. Боомтын хил нэвтрэх зам нь Монгол, Хятадын Хавирга- Ар хашаатын хилийн уулзалтын зам болно.

Энэхүү боомт нь хоёр талын шинжтэй, түр ажиллагаатай.

Жил бүрийн 1 дүгээр сарын 6-25, 4 дүгээр сарын 1-ээс 10 дугаар сарын 31-ийг дуустал хугацаанд боомтыг нээнэ. Нээх хугацаанд монголын талаас Улаанбаатарын цагаар 8:00-17:00(зуны цагийн тооллоор 9:00-18:00), хятадын талаас Бээжингийн цагаар 8:00-17:00 цагт ажиллуулна.

Хоёрдугаар хавсралт

МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛ ОРЧМЫН НУТАГТ ЗОРЧИХ ОЛОН УДААГИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

МОНГОЛ УЛС

蒙 古 国

(Соёмбо тэмдэг)

МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛ ОРЧМЫН НУТАГТ ЗОРЧИХ ҮНЭМЛЭХ

蒙 中 边 境 地 区

出 入 境 通 行 证

Нүүр

МОНГОЛ УЛС

(Соёмбо тэмдэг)

МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛ ОРЧМЫН НУТАГТ ЗОРЧИХ ҮНЭМЛЭХ

Нэгдүгээр нүүр

Зураг

No.

ҮНЭМЛЭХ ЭЗЭМШИГЧИЙН ГАРЫН ҮСЭГ

持证人签名

Bearer's signature

2

Хоёрдугаар нүүр

ОВОГ НЭР

姓名

Surname/Given name

ХҮЙС

性别

Sex

ЭРХЭЛДЭГ АЖИЛ

职业

Profession

ТӨРСӨН ОН, САР, ӨДӨР

出 生 日 期

Date of birth

ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХИЙН ДУГААР

身份证号码

ID No

ОРШИН СУУГАА ГАЗРЫН ХАЯГ

地址

Address

Гуравдугаар нүүр

АЯЛЛЫН ЗОРИЛГО

出境事由
Reason for exit

ОЧИХ ГАЗАР

前往地点
Destination

ГАРАХ, ОРОХ БООМТ

出入境口岸
Exit, entry port

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ

备注
Observation

ҮНЭМЛЭХ ХҮЧИНТЭЙ БАЙХ ХУГАЦАА
本证有效期
Date of expiry

ОНЫ	САРЫН	ӨДРӨӨС
自	年 月	日起
From	YY MM	DD

ОНЫ	САРЫН	ӨДӨР ХҮРТЭЛ
至	年 月	日止
TO	YY MM	DD

ҮНЭМЛЭХ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА
发证机关
Issued by

ТАМГА, ГАРЫН ҮСЭГ
盖印和签署
Seal and Signature

ОН	САР	ӨДӨР
年	月	日
YY	MM	DD

Тавдугаар нүүр

ХАМТ ЯВАА ХҮН

偕行人

The accompanied under 16 years old

Зураг

ОВОГ НЭР

姓名

Surname/Given name

ХҮЙС

性别

Sex

ТӨРСӨН ОН, САР, ӨДӨР

出 生 日 期

Date of birth

6

Зургадугаар нүүр

ХАМТ ЯВАА ХҮН

偕行人

The accompanied under 16 years old

ОВОГ НЭР

姓名

Surname/Given name

ХҮЙС

性别

Sex

ТӨРСӨН ОН, САР, ӨДӨР

出 生 日 期

Date of birth

Долдугаар нүүр

ШАЛГАЛТ

验 证

VALIDITY CHECKING

8-28

АНХААРАХ ЗҮЙЛ

1. Үнэмлэх эзэмшигч түүнд заасан хугацаа, боомтоор хил нэвтэрнэ.
2. Үнэмлэх эзэмшигчийн нөгөө талын нутагт байх удаа бүрийн хугацаа 30 хоногоос хэтрэхгүй байна.
3. Энэхүү үнэмлэхийг бусдад хэрэглүүлэхийг хориглоно. Түүнд засвар оруулсан бол хүчингүйд тооцно.
4. Энэхүү үнэмлэхийг үрэгдүүлбэл дотоодод үнэмлэх олгосон байгууллагад, хилийн гадна тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.
5. Үнэмлэхийн хүчинтэй хугацаа дууссаны дараа үнэмлэх олгосон байгууллагад буцааж өгнө.

Арын хавтасны дотор тал

Гуравдугаар хавсралт

МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛ ОРЧМЫН НУТАГТ ЗОРЧИХ НЭГ УДААГИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

МОНГОЛ УЛС

蒙 古 国

(Соёмбо тэмдэг)

МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛ ОРЧМЫН НУТАГТ ЗОРЧИХ ҮНЭМЛЭХ

蒙 中 边 境 地 区

出 入 境 通 行 证

Зураг

No.

ОВОГ НЭР
姓名
Surname/Given name

ХҮЙС
性别
Sex

ТӨРСӨН ОН, САР, ӨДӨР
出 生 日 期
Date of birth

ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХИЙН ДУГААР
身份证号码
ID No

ҮНЭМЛЭХ ЭЗЭМШИГЧИЙН ГАРЫН ҮСЭГ
持证人签名
Bearer's signature

Нүүрний дотор тал

ЭРХЭЛДЭГ АЖИЛ

职业

Profession

АЯЛЛЫН ЗОРИЛГО

出境事由
Reason for exit

ОЧИХ ГАЗАР

前往地点
Destination

ГАРАХ, ОРОХ БООМТ

出入境口岸
Exit，entry port

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ

备注
Observation

ҮНЭМЛЭХ ХҮЧИНТЭЙ БАЙХ ХУГАЦАА
本证有效期
Date of expiry

ОНЫ	САРЫН	ӨДРӨӨС
自	年 月	日起
From	YY MM	DD

ОНЫ	САРЫН	ӨДӨР ХҮРТЭЛ
至	年 月	日止
TO	YY MM	DD

ҮНЭМЛЭХ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА
发证机关
Issued by

ТАМГА, ГАРЫН ҮСЭГ
盖印和签署
Seal and Signature

ОН	САР	ӨДӨР
年	月	日
YY	MM	DD

Хоёрдугаар нүүр

ХАМТ ЯВАА ХҮН

偕行人

The accompanied under 16 years old

ОВОГ НЭР
姓名
Surname/Given name

ОВОГ НЭР
姓名
Surname/Given name

ХҮЙС
性别
Sex

ХҮЙС
性别
Sex

ТӨРСӨН ОН, САР, ӨДӨР
出 生 日 期
Date of birth

ТӨРСӨН ОН, САР, ӨДӨР
出 生 日 期
Date of birth

6

Гуравдугаар нүүр

ШАЛГАЛТ

验 证

VALIDITY CHECKING

ШАЛГАЛТ

验 证

VALIDITY CHECKING

Арын нүүрийн дотор тал

АНХААРАХ ЗҮЙЛ

6. Үнэмлэх эзэмшигч түүнд заасан хугацаа, боомтоор хил нэвтэрнэ.
7. Үнэмлэх эзэмшигчийн нөгөө талын нутагт байх удаа бүрийн хугацаа 30 хоногоос хэтрэхгүй байна.
8. Энэхүү үнэмлэхийг бусдад хэрэглүүлэхийг хориглоно. Түүнд засвар оруулсан бол хүчингүйд тооцно.
9. Энэхүү үнэмлэхийг үрэгдүүлбэл дотоодод үнэмлэх олгосон байгууллагад, хилийн гадна тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.
10. Үнэмлэхийн хүчинтэй хугацаа дууссаны дараа үнэмлэх олгосон байгууллагад буцааж өгнө.

Арын нүүрний гадна тал

МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛ ОРЧМЫН НУТАГТ ЗОРЧИХ ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАРЫН ТАЙЛБАР

1. Үнэмлэх 125 мм х 88 мм-ийн хэмжээтэй, олон удаагийн болон нэг удаагийн гэсэн хоёр төрөл байна. Олон удаагийн үнэмлэх нь 1 жилийн хугацаанд хүчинтэй, нэг удаагийн үнэмлэх нь 3 сарын хугацаанд хүчинтэй байна.

2. Үнэмлэхэд түүнийг эзэмшигчийн зураг, гарын үсэг байна. Зураг нь тамгаар баталгаажсан байна. Үнэмлэхэд эзэмшигчийн овог нэр, хүйс, төрсөн он, сар, өдөр, эрхэлдэг ажил, оршин суугаа газрын хаяг, аяллын зорилго, хил нэвтрэх боомт, үнэмлэхийн дугаар, хүчинтэй байх хугацаа, олгосон байгууллагын нэр, тамга болон олгосон он, сар, өдрийг тэмдэглэнэ.

3. Үнэмлэхийн нүүрний бичилтийг монгол, хятад хэлээр үйлдэнэ.

4. Үнэмлэхийн бичилтийг Талууд өөр өөрийн албан ёсны хэлээр бичих бөгөөд овог нэр, хүйс, эрхэлдэг ажил, аяллын зорилго, нэвтрэх боомтын нэрийг англи хэлээр давхар бичнэ. Тоо орсон бичлэгийг Араб тоогоор үйлдэнэ.

5. Үнэмлэхийг хэрэглэж эхлэхээс 30 хоногийн өмнө дипломат шугамаар нөгөө талдаа мэдэгдэж, загварыг өгнө. Хэрэв үнэмлэхийг өөрчлөх шаардлага гарвал Талууд хэлэлцэн тохиролцоно.

Дөрөвдүгээр хавсралт

МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛ ОРЧМЫН НУТАГТ ЗОРЧИХ ҮНЭМЛЭХ ҮРЭГДҮҮЛСНИЙГ НОТОЛСОН БИЧГИЙН ЗАГВАР

Тасалбар	Үнэмлэх үрэгдүүлснийг нотолсон бичиг
Дугаар Овог нэр Хүйс Үрэгдүүлсэн үнэмлэхийн дугаар Хил гарахыг зөвшөөрсөн хугацаа …….оны……сарын…..өдрөөс….. оны….. сарын …….өдөр хүртэл Хилээр гарах боомт	Үнэмлэх үрэгдүүлсэн тухай нотолгоо …….Улсын иргэн овог……..нэр…….. /хүйс/….. …. оны …..сарын……өдөр ……Улсын нутагт Монгол, Хятадын хил орчмын нутагт зорчих үнэмлэхээ /дугаар…….. / үрэгдүүлснийг үүгээр нотолж байна. Энэхүү нотолгоогоор…….оны……сарын…….өдрөөс өмнө ……хилийн боомтоор оршин суугаа газартаа буцахыг зөвшөөрөв. /Нотолгоо олгосон байгууллага, тамга/ ……оны……..сарын……..өдөр

8см

5 см 15 см

Тайлбар: Үнэмлэх үрэгдүүлснийг нотолсон бичгийн маягтыг Монгол, Хятад хэлээр хэвлэнэ.

ХИЛ ОРЧМЫН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖИЙН ЖАГСААЛТ

Монголын тал: 39 сум

Дорнод аймаг:	Эрээнцав, Чойбалсан, Баянтүмэн, Халх гол, Матад
Сүхбаатар аймаг:	Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр
Дорноговь аймаг:	Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг
Өмнөговь аймаг:	Ханбогд, Баян-Овоо, Номгон, Хүрмэн, Баяндалай, Ноён, Гурван тэс
Баянхонгор аймаг:	Шинэ жинст, Баян-Өндөр
Говь-Алтай аймаг:	Эрдэнэ, Цогт, Алтай, Бугат, Тонхил
Ховд аймаг:	Алтай, Үенч, Булган
Баян-Өлгий аймаг:	Булган, Дэлүүн, Алтай, Сагсай, Цэнгэл, Улаан хус

Хятадын тал: 27 хот, хошуу, шянь /уезд/

Өвөр Монголын Өөртөө Засах Орон:	Шинэ барга баруун хошуу, Шинэ барга зүүн хошуу, Рашаан хот, Хорчин баруун гарын өмнөд хошуу, Зүүн үзэмчин хошуу, Авга хошуу, Сөнөд зүүн хошуу, Эрээн хот, Сөнөд баруун хошуу, Дөрвөн вангийн хошуу, Дархан муумянганы холбоот хошуу, Улаат дунд хошуу, Улаат хойд хошуу, Алшаа зүүн хошуу, Алшаа баруун хошуу, Эзний хошуу
Ганьсу муж:	Субэй монгол үндэстний өөртөө засах шянь
Шиньжян Уйгарын Өөртөө Засах Орон:	Хами хот, Иү шянь, Баликунь шянь, Мулей шянь, Читай шянь, Чинхэ шянь, Фуюн шянь, Фухай шянь, Алтай хот, Боржин шянь

Зургаадугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТАНИХ ТЭМДГИЙН ЗАГВАР

Нүүрэн тал:



Ар тал:

Дугаар
Жолоочийн овог, нэр
Машины улсын дугаар
Хил нэвтрэх боомт
Хүчинтэй хугацаа
Олгосон байгууллага /Тамга/

Тайлбар:

1. Энэхүү таних тэмдгийг жолоочийн "Монгол, Хятадын хил орчмын нутагт зорчих үнэмлэх"-тэй хамт хэрэглэнэ.
2. Энэхүү таних тэмдгийг нөгөө Талын нутагт үрэгдүүлбэл тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

ХЯТАД, МОНГОЛЫН ХИЛИЙН БООМТ, ТЭДГЭЭРИЙН ДЭГЛЭМИЙН ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар /цаашид "Талууд" гэж нэрлэнэ/,

Хятад, Монголын ард түмний хоорондын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг улам хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор,

"Хятад,Монголын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар хоорондын Гэрээ" болон "Иргэд харилцан зорчих журмын тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг иш үндэс болгон,

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

I.Хоёр Тал хятад,монголын хилийн тодорхой хэсэг дээр хилийн боомт нээхээр тохиролцов.

2.Энэ зүйлийн нэгд заасны дагуу дор дурдсан хилийн боомтуудыг нээн ажиллуулна.

Хятадын талаас:	Монголын талаас:
Эрээн хот	Замын-Үүд
Ар хашаат	Хавирга
Зүүн хатавч	Бичигт
Ганц мод	Гашуун сухайт
Лаоемяо	Бургастай
Така Шикэн	Булган
Улиастай	Байтаг
Хун Шаньзюй	Даян

3.Энэхүү зүйлийн хоёрт дурдсан хилийн боомтын байршил, төрөл, ажиллах хугацааг нэгдүгээр хавсралтаар тодорхойлов.

Хоёрдугаар зүйл

1.Энэхүү хэлэлцээрийн нэгдүгээр зүйлийн хоёрт заасан хилийн боомтоор хил нэвтрэх болон энэ зүйлийн зургаад дурдсан хил орчмын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулах хүмүүс "Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэх"-тэйгээр, түүнд заасан хилийн боомтоор хил нэвтрэх болно.

Онцгой тохиолдол гарвал байгаа талын эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн энэхүү хэлэлцээрийн нэгдүгээр зүйлийн хоёрт заасан тухайн үед ажиллаж байгаа бусад боомтоор хил нэвтэрч болно.

Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхийг дор дурдсан хүмүүст олгоно.

а/хил орчмын худалдааны ажилтнууд /жолооч, ажилчид гэх мэт/;

б/хилийн албаны ажилтнууд;
в/хилийн боомтын хяналт шалгалтын ажилтнууд;

г/нөгөө талын хил орчмын нутаг дэвсгэрт байгаа төрөл садантайгаа уулзахаар яваа хил орчмын нутаг дэвсгэрт оршин суугч иргэд;

д/хил орчмын нутаг дэвсгэрийн бусад арга хэмжээнд оролцохоор уригдсан хүмүүс.

Дээр дурдсан хүмүүс хүчин төгөлдөр паспорттайгаар, "Иргэд харилцан зорчих журмын тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийн заалтыг баримтлан энэхүү хэлэлцээрийн нэгдүгээр зүйлийн хоёрт заасан боомтоор мөн адил хил нэвтэрч болно.

2.Энэ зүйлийн нэгд дурдсанаас бусад хүмүүс энэхүү хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд заасан хилийн боомтоор нэвтрэх, энэ зүйлийн нэгд дурдсан хүмүүс энэ зүйлийн зургаад заасан нутаг дэвсгэрээс өөр газарт үйл ажиллагаагаа явуулбал өөрийн улсын эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр паспорттай байх бөгөөд "Иргэд харилцан зорчих журмын тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийн заалтыг баримтална.

3.Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхийг хятад, монгол хоёр хэлээр үйлдэх бөгөөд түүнийг тус тусын орон нутгийн эрх бүхий байгууллагаас олгоно.Үнэмлэхийн тайлбарыг хоёрдугаар хавсралтаар тодорхойлов.

4.Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэх бүхий иргэн 16 нас хүрээгүй хүүхэд дагуулан яваа бол түүний үнэмлэхэд тэмдэглэнэ.

5.Нэг Талын иргэн хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхээ нөгөө Талын нутагт үрэгдүүлбэл тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэж, энэхүү байгууллагаас үнэмлэхээ үрэгдүүлснийг нотолсон бичиг авч хил гарна.Үнэмлэхээ үрэгдүүлснийг нотолсон бичгийн загвар нь гуравдугаар хавсралтаар тодорхойлов.

6.Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхээр хил нэвтэрсэн хоёр талын иргэд түүний үнэмлэхэд заасан хүрэлцээнд болон очих газрын засаг захиргааны нэгжийн хязгаар дотор үйл ажиллагаагаа явуулна.Байх хугацаа нь 90 хоногоос хэтрэхгүй байна.Үнэмлэх бүхий иргэн нөгөө талдаа 90 хоногоос илүү хугацаатай байх шаардлага гарвал нөгөө талын эрх бүхий байгууллагад хугацаагаа сунгуулах хүсэлт тавих бөгөөд энэхүү байгууллага түүнийг зөвхөн нэг удаа сунгана.

Хоёр Тал Хятад,Монголын "хил орчмын нутаг дэвсгэр" гэдэгт Бүгд Найрамдах Монгол Ард Улстай хил залгаа Бүгд Най-

рамдах Хятад Ард Улсын сум, хошуу, хотууд, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хил залгаа Бүгд Найрамдах Монгол Ард Улсын сумыг тооцно.

Энд заасан засаг захиргааны нэгжийн жагсаалтыг дэрэвдүгээр хавсралтаар тодорхойлов.

7.Аль нэг гуравдахь улс /район/-ын иргэд энэхүү хэлэлцээрийн нэгдүгээр хавсралтад дурдсан байнгын ажиллагаатай боомтоор хил нэвтрэх шаардлага гарвал хүчин төгөлдөр паспорт болон орох визтэй байна.

Хэрэв дээр дурдсан иргэд энэхүү хэлэлцээрийн нэгдүгээр хавсралтад дурдсан улирлын ажиллагаатай боомтоор хил нэвтрэх шаардлага гарвал хүчин төгөлдөр паспорт болон орох визтэй байх бөгөөд хоёр талын гадаад харилцааны байгууллагаас тусгай зөвшөөрөл авна.

8.Хил орчмын худалдааны хоёр талын хүмүүс болон тээврийн хэрэгсэл "Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэх"-д заасан боомтоор хил нэвтрэх бөгөөд нөгөө талын нутаг дэвсгэрт орсны дараа заасан замаар аялж, заасан талбайд ачаа тээшээ буулгана.

Дээр дурдсан тээврийн хэрэгсэл нь урьдчилан тохиролцсон таних тэмдэгтэй байна.Таних тэмдгийн загварыг тавдугаар хавсралтаар тодорхойлов.

9.Хилийн боомтоор нэвтрэх зорчигч болон тээврийн хэрэгслийг зохицуулах журмыг хоёр талын холбогдох байгууллагууд энэ хэлэлцээрийн үндсэн дээр тохиролцоно.

Гуравдугаар зүйл

Боомтыг нээн ажиллуулах үеэр хоёр талын хилийн хяналт шалгалтын байгууллагууд тус тусын улсын хууль тогтоомжийн дагуу үүргээ гүйцэтгэнэ.

Дөрөвдүгээр зүйл

1.Хоёр Тал хилийн боомт шинээр нээх буюу одоо байгаа боомтыг бүрмөсөн хаах асуудлыг дипломат шугамаар тохиролцож,энэ тухай баримт бичгийг энэхүү хэлэлцээрийн нэмэлт болгоно.

2.Хоёр Талын хилийн боомтын холбогдох байгууллагууд шийдвэрлэж чадаагүй аливаа маргаантай асуудлыг дипломат шугамаар зохицуулж байна.

Тавдугаар зүйл

1.Энэхүү хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд дурдсан боомтууд нээлттэй байхаас бусад хугацаанд онцгой тохиолдол гарвал хоёр Тал харилцан тохиролцсоны үндсэн дээр дээрх боомтуудыг түр нээж болно.

2.Урьдчилан харах боломжгүй нөхцөлд аль нэг Тал нь хилийн боомтыг түр хаах буюу нээхийг хойшлуулж болно.Ийнхүү хаах буюу нээхийг хойшлуулах болсон шалтгаан, хугацааг хоёр Тал бие биедээ аль болох богино хугацаанд мэдэгдэнэ.

3.Энэ зүйлийн хоёрт дурдсанаас бусад тохиолдолд аль нэг Тал нөгөө Талын зөвшөөрөлгүйгээр хилийн боомтыг хаах буюу нээхийг хойшлуулснаас нөгөө Талд учирсан хохирлыг зохих хэмжээгээр төлнө.

Зургадугаар зүйл

Хилийн боомтоор нэвтэрч буй хүмүүс нөгөө Талын нутаг дэвсгэрт байхдаа тухайн улсын хууль тогтоомжийг хүндэтгэх үүрэгтэй.

Долдугаар зүйл

Хоёр Талын холбогдох байгууллагууд хилийн боомтын асуудлаар харилцахдаа "Хятад,Монголын хилийн дэглэм,хилийн асуудлыг зохицуулж байх тухай Бүгд Найрамдах Хятад Ард

Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар хоорондын Гэрээ"-ний 17 болон 19 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

Наймдугаар зүйл

Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр байх хугацаанд хоёр Тал харилцан тохиролцсоны үндсэн дээр түүнд өөрчлөлт,нэмэлт оруулж болно.

Есдүгээр зүйл

Энэхүү хэлэлцээр нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Энэхүү хэлэлцээрийг таван жилийн хугацаатайгаар байгуулсан бөгөөд хоёр Талын аль нэг нь нөгөө Талд энэхүү хэлэлцээрийн хугацаа дуусахаас 6 сарын өмнө түүнийг цуцлах тухай саналаа бичгээр мэдэгдээгүй бол хүчинтэй байх хугацаа нь тав таван жилээр аяндаа сунгагдаж байна.

Энэхүү хэлэлцээрийг 1991 оны зургадугаар сарын 24 өдөр Бээжин хотноо хятад, монгол хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй болно.

БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС

徐敦信

БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС

Нэгдүгээр хавсралт

ХЯТАД,МОНГОЛЫН ХИЛИЙН БООМТУУДЫН БАЙРШИЛ,ТӨРӨЛ,АЖИЛЛАХ ХУГАЦАА

I.Эрээн - Замын-Үүдийн боомт

Энэхүү боомт нь Хятад,Монголын хилийн 357 дугаар тэмдгийн орчимд байна.БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны Эрээн хот, БНМАУ-ын Дорноговь аймгийн Замын-Үүд боомтын хоёр талд оршино.Боомт нь байнгын ажиллагаатай.Боомтоор Хятад,Монголын иргэд, бараа, тээврийн хэрэгслэл мөн гуравдахь орны иргэд хил нэвтэрнэ.Боомт нь Бээжин-Улаанбаатарын цагаар 09.00-17.00 цаг хүртэл ажиллана.

2.Ар хашаат - Хавиргын боомт

Энэхүү боомт нь Хятад,Монголын хилийн 622 дугаар тэмдгийн орчимд байна.БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны Хөлөнбуйр аймгийн Шинэ барга баруун хошуу, БНМАУ-ын Дорнод аймгийн Чойбалсан сум боомтын хоёр талд оршино.

Энэхүү боомт нь хоёр Талын шинжтэй, улирлын чанартай. Хоёр Талын иргэд, хил орчмын худалдааны бараа, тээврийн хэрэгслийг энэ боомтоор хил нэвтрүүлнэ.

Боомтын хил нэвтрэх зам нь Хятад,Монголын Ар хашаат - Хавиргын хилийн уулзалтын зам болно.

Жил бүрийн I,4,7,I0 дугаар сарын I-I5 хүртэлх хугацаанд боомтыг нээж, өдөр бүр Бээжин-Улаанбаатарын цагаар 09.00-I7.00 цагт ажиллуулна.

3.Зүүн хатавч - Бичигтийн боомт

Энэхүү боомт нь Хятад,Монголын хилийн 452 дугаар тэмдгийн орчимд байна.БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошуу, БНМАУ-ын Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум боомтын хоёр талд оршино.

Энэхүү боомт нь хоёр Талын шинжтэй, улирлын чанартай. Хоёр Талын иргэд, хил орчмын худалдааны бараа, тээврийн хэрэгслийг энэ боомтоор хил нэвтрүүлнэ.

Боомтын хил нэвтрэх зам нь Хятад,Монголын Зүүн хатавч-Бичигтийн хилийн уулзалтын зам болно.

Хил бүрийн I,4,7,I0 дугаар сарын I-I5 хүртэлх хугацаанд боомтыг нээж, өдөр бүр Бээжин-Улаанбаатарын цагаар 09.00-I7.00 цагт ажиллуулна.

4.Ганц мод - Гашуун сухайтын боомт

Энэхүү боомт нь Хятад,Монголын хилийн 288 дугаар тэмдгийн орчимд байна.БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны Баян нуур аймгийн Улаат дунд хошуу, БНМАУ-ын Өмнөговь аймгийн Хан богд сум боомтын хоёр талд оршино.

Энэхүү боомт нь хоёр Талын шинжтэй, улирлын чанартай. Хоёр Талын иргэд, хил орчмын худалдааны бараа, тээврийн хэрэгслийг энэ боомтоор хил нэвтрүүлнэ.

Боомтын хил нэвтрэх зам нь Хятад,Монголын Ганц мод-Гашуун сухайтын хилийн уулзалтын зам болно.

Хил бүрийн I,4,7,I0 дугаар сарын I-I5 хүртэлх хугацаанд боомтыг нээж, өдөр бүр Бээжин-Улаанбаатарын цагаар 09.00-I7.00 цагт ажиллуулна.

5.Дасэмяо - Бургастайн боомт

Энэхүү боомт нь Хятад,Монголын хилийн I42 дугаар тэмдгийн орчимд байна.БНХАУ-ын Шиньзян Уйгарын Өөртөө засах орны Хами районы Баликунь сум, БНМАУ-ын Говь-Алтай аймгийн Алтай сум боомтын хоёр талд оршино.

Энэхүү боомт нь хоёр Талын шинжтэй, улирлын чанартай. Хоёр Талын иргэд, хил орчмын худалдааны бараа, тээврийн хэрэгслийг энэ боомтоор хил нэвтрүүлнэ.

Боомтын хил нэвтрэх зам нь Хятад,Монголын Лаоемяо-Бургастайн хилийн уулзалтын зам болно.

Жил бүрийн 3,6,8,11 дүгээр сарын 15-30 хүртэлх хугацаанд боомтыг нээж, өдөр бүр Бэжин-Улаанбаатарын цагаар 11.00-18.00 цагт ажиллуулна.

6.Улиастай - Байтагийн боомт

Энэхүү боомт нь Хятад,Монголын хилийн 73 дугаар тэмдгийн орчимд байна.БНХАУ-ын Шиньзян Уйгарын Өөртөө засах орны Цонжийн хотон үндэстний өөртөө засах тойргийн Читай сум, БНМАУ-ын Ховд аймгийн Булган сум боомтын хоёр талд оршино.

Энэхүү боомт нь хоёр Талын шинжтэй, улирлын чанартай. Хоёр Талын иргэд, хил орчмын худалдааны бараа, тээврийн хэрэгслийг энэ боомтоор хил нэвтрүүлнэ.

Боомтын хил нэвтрэх зам нь Хятад,Монголын Улиастай-Байтагийн хилийн уулзалтын зам болно.

Жил бүрийн 3,6,8,11 дүгээр сарын 1-15 хүртэлх хугацаанд боомтыг нээж, өдөр бүр Бэжин-Улаанбаатарын цагаар 11.00-18.00 цагт ажиллуулна.

7.Такашикэн - Булганы боомт

Энэхүү боомт нь Хятад,Монголын хилийн 58 дугаар тэмдгийн орчимд байна.БНХАУ-ын Шиньзян Уйгарын Өөртөө засах орны Алтай районы Чинхэ сум, БНМАУ-ын Ховд аймгийн Булган сум боомтын хоёр талд оршино.

Энэхүү боомт нь хоёр Талын шинжтэй, улирлын чанартай.

Хоёр Талын иргэд, хил орчмын худалдааны бараа, тээврийн хэрэгслийг энэ боомтоор хил нэвтрүүлнэ.

Боомтын хил нэвтрэх зам нь Хятад,Монголын Такашкэн-Булганы хилийн уулзалтын зам болно.

Хил бүрийн 4-12 дугаар сарын 20-30 хүртэлх хугацаанд боомтыг нээж, өдөр бүр Бээжин-Улаанбаатарын цагаар 11.00-18.00 цагт ажиллуулна.

8.Хуншаньзюй - Даянгийн боомт

Энэхүү боомт нь Хятад,Монголын хилийн 12 дугаар тэмдгийн орчимд байна.БНХАУ-ын Шиньзян Уйгарын өөртөө засах орны Алтай районы Фухай сум, БНМАУ-ын Баян-Өлгий аймгийн Сагсай сум боомтын хоёр талд оршино.

Энэхүү боомт нь хоёр Талын шинэхтэй, улирлын чанартай. Хоёр Талын иргэд, хил орчмын худалцааны бараа, тээврийн хэрэгслийг энэ боомтоор хил нэвтрүүлнэ.

Боомтын хил нэвтрэх зам нь Хятад,Монголын Хуншаньзюй-Даянгийн хилийн уулзалтын зам болно.

Хил бүрийн 7,8,9 дүгээр сарын 1-10 хүртэлх хугацаанд боомтыг нээж, өдөр бүр Бээжин-Улаанбаатарын цагаар 11.00-18.00 цагт ажиллуулна.

Хоёрдугаар хавсралт

ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ЗОРЧИХ ҮНЭМЛЭХИЙН ТАЙЛБАР

I.Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхэд түүний эзэмшигчийн зураг байна.Мөн эзэмшигчийн гарын үсэг, үнэмлэхийн дугаар, овог нэр, хүйс, төрсөн он, сар, өдөр, мэргэжил, иргэний паспортын дугаар, ямар зорилгоор явах /албан, хувийн/, оршин суугаа газрын хаяг, хил нэвтрэх боомт, байх хаяг, хамт яваа 0-I6 насны хүүхэд /зураг наана/, үнэмлэх хүчинтэй байх хугацаа, үнэмлэх олгосон эрх бүхий байгууллага, он, сар, өдөр.

2.Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхийг хэрэглэж эхлэхээс 30 хоногийн өмнө дипломат шугамаар нөгөө талдаа мэдэгдэж загварыг өгнө.Хэрэв үнэмлэхийг өөрчлөх шаардлага гарвал хоёр талдаа хэлэлцэн шийдвэрлэнэ.

Гуравдугаар хавсралт

ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ЗОРЧИХ ҮНЭМЛЭХЭЭ
ҮРЭГДҮҮЛСНИЙГ НОТЛОХ БИЧГИЙН ЗАГВАР

№

Овог нэр.....
.....
/хүйс/

Үрэгдүүлсэн хил орчмын нутагт
зорчих үнэмлэхийн № ...
Ямар боомтоор хил гарах,хугацаа

үлдэх хувь 5 см

№

Үнэмлэх үрэгдүүлсэн тухай нотолгоо
.....Улсын иргэн...../хүйс/
I9.. оны .. сар .. өдөр .....улсын
нутаг дэвсгэрт хил орчмын нутагт зорчих үнэмлэхээ /№/ үрэгдүүлснийг үүгээр нотолж байна. Энэхүү нотолгоогоор .... он .. сар .. өдрөөс өмнө .....хилийн боомтоор эх орондоо буцахыг зөвшөөрөв.

Баримт бичгийг олгосон байгууллага /тамга/

Гарын үсэг

.... он .. сар .. өдөр

өгөх хувь I5 см

Тайлбар: Үнэмлэх үрэгдүүлсэн нотолгоог хятад,монгол хэлээр үйлдэнэ.

Дөрөвдүгээр хавсралт

ХЯТАД,МОНГОЛЫН ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖИЙН ЖАГСААЛТ

Хятадын тал: /26 сум, хот,хошуу/

Өвөрмонголын өөртөө засах орон:	-Шинэ барга баруун хошуу, Шинэ барга зүүн хошуу,Хорчин баруун гарын өмнөд хошуу,Зүүн үзэмчин хошуу,Авга хошуу, Сөнөд зүүн хошуу, Эрээн хот, Сөнөд баруун хошуу, Дөрвөн вангийн хошуу, Дархан муумянганы холбоот хошуу, Улаат дунд хошуу, Улаат хойд хошуу, Алшаа зүүн хошуу, Алшаа баруун хошуу, Эзний хошуу
Гансу муж:	-Монгол үндэстний өөртөө засах Сүбэ сум
Шиньзян Уйгарын өөртөө засах орон:	-Хами хот, Иү сум, Балыкунь сум,Мулей сум, Читай сум, Чинхэ сум,Фукинь сум, Фухай сум, Алтай хот, Боржин сум

Монголын тал: /39 сум/

Дорнод аймаг:	-Эрээнцав, Чойбалсан, Баянтүмэн, Сүмбэр, Халх гол, Матад
Сүхбаатар аймаг:	-Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр
Дорноговь аймаг:	-Өргөн, Эрдэнэ /Замын-Үүд/, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг
Өмнөговь аймаг:	-Ханбогд, Баян-Овоо, Номгон, Хүрмэн, Баяндалай, Ноён, Гурван тэс
Баянхонгор аймаг:	-Шинэ жинст, Баян-Өндөр
Говь-Алтай аймаг:	-Эрдэнэ, Цогт, Алтай, Бугат, Тонхил
Ховд аймаг:	-Алтай, Үенч, Булган
Баян-Өлгий аймаг:	-Булган, Дэлүүн, Алтай, Сагсай, Цэнгэл, Улаан хус

Тайлбар: Хэрэв аль нэг Талын хил орчмын нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжид өөрчлөлт гарвал, нэн даруй нөгөө Талдаа мэдэгдэнэ.

Тавдугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТАНИХ ТЭМДГИЙН
З А Г В А Р

Нүүрэн тал:



Ар тал:

№.....
Холоочийн овог, нэр.....
Улсын дугаар.....
Хил нэвтрэх бооомт.....
Хүчинтэй хугацаа.....
Олгосон байгууллага.....
Он, сар, өдөр.....

/Тамга/